

Хүүхдэд зориулсан Библи
танилцуулж байна

Баян хүн,
Ядуу
хүн



Зохиогч: Edward Hughes

Зураглаач: M. Maillot; Lazarus

Найруулсан: M. Maillot; Sarah S.

Орчуулсан: Damdin Horolsuren

Бүтээсэн: Bible for Children

www.M1914.org

©2014 Bible for Children, Inc.

**Зөвшөөрөл: Та энэ бүтээлийг хувилах хуулах
эрхтэй харин худалдахыг хориглоно.**



**Олон шашны удирдагч нар
Бурханыг хайрлахаасаа
илүү мөнгийг хайрлаж
байгааг Есүс
мэдэж байв.**



**Тэр Бурхан байхгүй бол мөнгө
байгаад нэмэргүй гээд хоёр
хүний түүхийг ярив.**



**Хүн баян байсан ч Диваажинд
буй Бурханаас амь худалдан
авч чадахгүй юм.**



Нэгэн баян хүн
байсан бөгөөд
үнэтэй гоёмсог
хувцас өмсдөг
байв. Тэр яг
л хаан шиг
хувцасладаг
байжээ.




**Тэр баян хүн төрөл бүрийн амттай
зоог баридаг байв. Түүний хоол унд
нь найрын ширээ
адил байдаг
байв.**



**Тэр маш их мөнгөтэй учир өөрийн
хүссэн амттан хоол зуушийг өглөө,
өдөр, оройн хоолондоо
иддэг байжээ.**




**Тэр баян айлыг үүдэнд нэгэн ядуу,
өвчтэй өлсгөлөн гуйлгачин
эр хаалгыг нь сахин**



ХЭВТДЭГ байв.



Түүний нэрийг Лазар гэдэг ажээ.




**Ядуу Лазар
яр шархандаа
баригдсан байлаа.
Тэр халдварт
ӨВЧИНТЭЙ
байсан
ч байж
магадгүй.**



**Бусад хүмүүс түүнийг
зодож гэмтээсэн ч
байж болох юм. Тэр
хоол хүнс, мах, сүү, бас
ногоо хангалттай
идээгүйгээс
өвчин туссан
ч байж болох
юм.**



Лазар хоол
хүлээж
суудаг
байлаа.



Тэр баян
хүний
зоогийн
ширээнээс
өвдөл
цөвдөл
унахад маш
их баярладаг
байв.



**Ядуу эрийг
золбин
ноход
дагадаг
байв.**



Тэд түүний
яр шархыг
долоодог
байлаа.
Учир нь
Лазарыг
асрах хэн ч
байсангүй.



Нэгэн
өглөө
Лазар
сэрсэнгүй.



**Ядуу найз
нөхөдгүй
өлсгөлөн
Лазар энэ
амьдралыг
орхижээ.
Тэр үхсэн
байв.**



**Лазарыг үхэх агшинд
түүнд зориулсан баяр хөөр
ЭХЛЭВ.**




**Есүс тэнгэр элч нарт
түүнийг Абрахамын өвөр дээр
тавихыг тушаав. Бурхан
Лазарыг тайвшруулжээ.**



Баян хүн ч бас үхжээ. Түүний
бүх хөрөнгө мөнгө нь түүний амийг
аварч чадсангүй.



Үхэл ирэх үед
ХЭН Ч ЗОГСООЖ
ЧАДАХГҮЙ БИЛЭЭ.



**Баян хүнийг оршуулжээ. Магадгүй
түүний булш их том байсан байх.**



**Хүмүүс баян эрийг магтаж ухаантай
амжилттай эр гэж хэлж байсан
байх.**



**Гэвч тэдний магтаал түүнд өчүүхэн
ч тус болсонгүй. Баян хүн
тамд унажээ.**



Тамаас тэр хашхирч "Абрахам
Эцэгээ Лазарыг нааш нь явуулаач, ...




... би энэ галд шатаж үхлээ тэр
хуруугаа усанд дүрээд миний аманд
хий гэж хэлээч''


ГЭЖЭЭ.



Абрахам хариуд нь
"Чи амьдралынхаа
туршид сайныгаа
авсан харин Лазар
юу ч аваагүй", ...



... гээд "Одоо чи
тэнд зовж харин
Лазар энд тайтгарч
байна" гэв. "Чи
бидний хооронд хэн
ч үл очиж чадах том
ангал тогтжээ" гэв.



"Эцэг ээ, тэгвэл
түүнийг миний эцгийн
гэрт илгээхийг би танаас
гуйя. Би
таван
дүүтэй.




Энэхүү тарчлалын газар
тэднийг ирүүлэхгүйн тулд
Лазар тэдэнд сануулаг"
ГЭЖ ХЭЛЖЭЭ.



Харин Абрахам "Тэдэнд
Бурханы үг байгаа шүү
дээ" гэв.



**Хэрэв тэд Библид
итгэдэггүй юм бол Лазар
үхлээс амилсан ч тэд
үнэмшихгүй
биз дээ гэв.**



**Есүсийг баян эр болон Лазарыг
тухай түүхийг ярьж дуусахад
шашны удирдагч нар
өөрсдөөсөө "Би мөнгыг
Бурханаас илүү хайрлаж
байна
уу?"**



**ХЭМЭЭН ӨӨРӨӨСДӨӨСӨӨ АСУУСАН
БАЙХ. Ингээд тэд Бурханыг
үгийг сонсохгүй бол юу
ТОХИОЛДОХ талаар
МЭДЭЖ
АВЧЭЭ.**



Баян хүн, Ядуу хүн

Бурханы үг Библиээс авсан түүх

Лук 16

"Таны үгсийн тунхаглал гэгээрүүлдэг."

Дуулал 119:130



Төгсөв



Библийн түүх нь гайхамшигт Бурхан биднийг бүтээсэн бөгөөд таныг өөрийгөө мэдээсэй гэж хүсдэг тухай бидэнд хэлдэг.

Бурхны гэм гэж нэрлэдэг муу зүйлийг бид үргэлж хийдгийг Бурхан сайн мэднэ. Гэмийн шийтгэл нь үхэл боловч Бурхан танд маш их хайртай учир Тэрээр цорын ганц хүү Есүсийг таны гэмийн өмнөөс шийтгүүлэн загалмайд цовдлогдон үхэхийг зөвшөөрөн энэ дэлхийд илгээсэн юм. Тэгээд Есүс дахин амилж тэнгэр дэх гэртээ буцсан! Хэрвээ та Есүст итгэж түүнээс гэмийнхээ төлөө уучлал гуйвал Тэрээр таныг уучлах болно! Тэрээр таньруу ирэх бөгөөд тантай хамт байх болно мөн та түүнтэй мөнхөд хамт амьдрах болно.



**Хэрвээ та энэ үнэнд итгэж
байвал Бурханд хандан ийнхүү хэлээрэй:
Эрхэм Есүсээ, Би таныг Бурхан гэдэгт болон
миний гэмийн төлөө үхсэн гэдэгт мөн одоо та
амьд гэдэгт итгэж байна. Миний амьдралд орж
ирээд миний гэмийг уучлаач, тэгээд Би одооноос
эхлээд шинэ амьдралаар амьдарч нэг өдөр
тантай хамт мөнхөд байхаар явах болно. Танд
дуулгавартай байж таны хүүхэд шиг таны төлөө
амьдрахад туслаач. Амен.**

**Библи уншиж өдөр бүр Бурхантай
ярилцаарай! Иохан 3:16**

